



Монгол Улс:  
Институцийн өөрчлөлт хийх замаар  
эрдэс баялгийн менежментийг  
сайжруулах төсөл

Үр дүнд суурилсан удирдлагын арга дахь жендэр

Илтгэгч: MERIT төслийн Техникийн зөвлөх Реймонд Жирвэй

2018 оны 5 сарын 31

ТЗ Жинетт Жонстоны сургалтын материалыг ашиглав

# Зорилго

Энэхүү сургалтын модулийн зорилго нь **жендэр** ба **жендэрийн эрх тэгш байдлын** үндсэн ойлголтыг Үр дүнд суурилсан удирдлагын аргатай холбох, нэгтгэх явдал юм.

# Хүлээгдэж буй үр дүн

- Оролцогчид жендэр болон хүйсийн талаар **илүү сайн ойлголттой** болно.
- Жендэрийн **эрх тэгш байдал**, жендэрийн **харилцааг** танилцуулна.
- Оролцогчид жендэр болон үр дүнд суурилсан удирдлагын процесс, хэрэгслийн хоорондын **холбоосыг** бий болгоно.
- Жендэрийн **үр дүнгийн гинжин холбоотой** танилцана.
- Жендэрийн **мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүдийг** авч үзэх болно.

# 1.0 Тодорхойлолт: Жендэр ба хүйс

Түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг мөн уламжлагдан тогтсон улс төр, эдийн засаг, нийгэм, соёл ба гэр бүлд эрэгтэй эсвэл эмэгтэй хүний хүлээх үүрэг, хариуцлага, байр суурийн талаарх ойлголт.

<b>Хүйс</b>	<b>Жендэр</b>
Биологийн шинжээр тодорхойлогдсон	Нийгмээр цогцлогдсон
Хаана ч нийтлэг	Олон талт: соёл, газарзүйн байршил, цаг уураас хамааран ялгаатай
Харьцангуй тогтмол	Динамик, түүхэн явцад өөрчлөгддөг

# Тодорхойлолт: Жендэрийн эрх тэгш байдал ба харилцаа

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүд, охид хөвгүүд адил тэгш **эрх, хариуцлага, боломж** эдлэх .

Нөөцийн эрх мэдэл, хүртээмж, хяналтыг хоёр хүйсийн хооронд хэрхэн хуваарилсан талаарх харилцааг багтаасан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байдаг **жендэрийн харилцаа**.

# Монгол Улс ба Жендэр: Хууль болон зарчим

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн **зарчим**:

Тэгш эрхийн зарчим

Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим

Төрийн хариуцлагын зарчим

Жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим

Жендэрийн мэдрэмжтэй мэдээллийн зарчим

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө ҮДСУ-д суурилбал нь эдгээр зарчмыг **хэрэгжүүлэх боломжтой**.

## “Монгол дахь жендэрийн асуудал” баримт бичгийн судалгаа, IRIM судалгааны хүрээлэн, 2014:

Монгол улс дахь жендэрийн тэгш байдлыг хангахад шаардлагатай зохицуулалтын хүрээ харьцангуй **хүчтэй**

Монгол улсын нийгэм, эдийн засгийн голлох салбаруудад ажил эрхэлж буй нийт иргэдийн дунд хүйсийн хуваарилалт хэдийн ил болсон байдаг ба хөдөлмөрийн зах зээл дээр **ажил, мэргэжлүүд хүйсээр ангилагдсан байх нь элбэг**.

**Тэгш цалин хөлс олгох тал** дээр жендэрийн **зөрүүтэй** байдал хэвээр байна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдэл Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдлын индексүүдийн **хамгийн бага индекстэй** үзүүлэлтийн нэг хэвээр байна.

Монгол улсын **боловсролын салбар**, тэр дундаа дээд боловсролын салбарт жендэрийн зөрүүтэй байдал эсрэгээрээ байна.

**Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал доройтож байгаа**тай холбоотой зарим анхаарал татсан асуудал үүсч байна.

**Гэр бүлийн хүчирхийлэл** монгол эмэгтэйчүүдийн хувьд тулгамдсан асуудал болж байна.

Үндэсний хэмжээнд бүх салбарын статистик мэдээллийг **хангалттай** түвшинд хүйсээр **ангилж чадахгүй** байна.

## Байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ (ойн салбарын жишээ), IRIM судалгааны хүрээлэн, 2017:

Ерөнхий: Эмэгтэйчүүд нь боловсрол, эрүүл мэнд гэх мэт шаардлагатай 'чадамж'-ийг эзэмшсэн байгаа ч тухайн **чадамжаа ашиглах, боломж, давуу тал болгох байдал ойн салбарт дутмаг байна.**

1. Хөдөлмөрийн зах зээлд эрэгтэй, эрэгтэй хүмүүст **ялгаатай байдлаар хандах нь түгээмэл** байна.
2. Жендэр болон байгаль орчинтой холбоотой **хуулийн хэрэгжилт сул хэвээр байна.**
3. Жендэрийн нэвтрүүлэх үйл ажиллагаанд үзүүлэх **орон нутгийн оролцох үүрэг хангангалттай бус байна**
4. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өөр өөр түвшний оролцоо нь тэдний биеийн хүч болон нийгмийн онцлог, үүргийн хуваарилалтын талаарх **ойлголттой** холбоотой олон хүчин зүйлээс хамаарч байна.
5. Оролцогч талууд ихэвчлэн Монголд ойн бизнесийг **эрэгтэйчүүд давамгайлсан** байдаг гэж үзэх хандлагатай байдаг.
6. Ойн салбарын ажил эрхлэлт жендэр, боловсрол, насны байдлаар **хуваагдсан байдаг.**
7. Байгаль орчны салбарт шийдвэр гаргах албан тушаалд байгаа **эмэгтэйчүүдийн тоо, эрэгтэйчүүдийн тооноос бага байна.**
8. Монголд ойн салбарын **жендэртэй холбоотой статистик мэдээлэл** хязгаарлагдмал байна.



# Монгол Улс ба Жендэр:

## гадны нүдээр

### **НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тайлан:**

Эмэгтэйчүүдийн дийлэнх нь ялангуяа хөдөө орон нутагт **цалин хөлсгүй** гэрийн ажил хийдэг.

**Хот, хөдөөгийн ялгаатай байдал** болон хотжилт, шилжин суурьшилттай холбоотой тулгамдсан асуудал газарзүйн хувьд тархсан хүн амд, ялангуяа залуучуудад, ижил боломжоор хангахад асар их сорилттой тулгарч байна


**Нийгмийн хэвшмэл ойлголт** болон уламжлалт гэр бүлийн үүрэг эмэгтэйчүүдийг ажил хийхэд хязгаарлах хүчин зүйл болж байна

Эх үүсвэр: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, 2016

# Жендэрийг тусгах гэж юу вэ?

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах,  
эмэгтэйчүүдийн эрх мэдлийг  
нэмэгдүүлэх **стратеги**

Хийх арга зам: Төслийн мөчлөгийн  
бүрэлдэхүүн бүр(т) жендэр(т) хэрхэн  
нөлөөлж байгааг **үнэлэх**. **Жендэрийн дүн  
шинжилгээ** нь энэ үйл явцад голлох  
үүрэгтэй.



# Жендэрийн дүн шинжилгээ

Жендэрийн дүн шинжилгээ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын **харилцааг** судалж үздэг. Энэ нь өрхийн болон олон нийтийн, ажлын байр, улс төрийн үйл явц, эдийн засагт эмэгтэйчүүд эрэгтэйчүүд, охид хөвгүүдийн **янз бүрийн үүргийг** тодорхойлдог. Ийм ялгаатай үүргээс улбаалаад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол нөөц, шийдвэр гаргах үйл явцад **бага оролцож**, тэдгээр үйл явцыг хянах **боломж бага байдаг**.

Жендэрийн үр дүнтэй дүн шинжилгээ хийх нь төсөл эсвэл хөтөлбөрийн **эхний үе шатанд** хийгдэх шаардлагатай бөгөөд үр дүнг төсөл, хөтөлбөрийн төлөвлөлтөд нэгтгэсэн байх ёстой. Цаашлаад нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн **туршид** хийгдэх ёстой.

# Жендэрийн дүн шинжилгээг хийх алхмууд



# Алхам 1: Асуудлыг тодорхойлох

Асуудлыг тодорхойлох, сайжруулахад жендэрийн талаас авч үзвэл:

- эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн янз бүрийн, өөр өөр туршлагыг харгалзан үзэхийн тулд асуудал, зорилтот бүлгийг тодорхойлох;
- эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх;
- эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг оролцуулан тэдний асуудлыг тодорхойлох ;
- нас болон бусад хүчин зүйлсээс шалтгаалж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн туршлага хэрхэн өөр байдаг талаар;
- хүчин зүйл (соёл, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн гэх мэт) нь энэ асуудлын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад нөлөөлж болно.

## Алхам 2: Таамаглал

Таамаглалууд нь (хувийн, нийгэм, улс төрийн) дүн шинжилгээнд нөлөөлж болно.

Дүн шинжилгээг хийхэд хувь хүний болон байгууллагын жендэрийн ойлголтын төсөөллийг оруулж өгвөл шинжилгээ илүү мэдрэмжтэй, хүчирхэг, илүү сайн үндэслэлтэй болж чадна.

## Алхам 3: Баримтыг цуглуулах

Таны санаачлагыг тодорхой бүлэг хүмүүст илүү их нөлөө үзүүлэх эсэх, эсвэл саад бэрхшээл байгаа эсэхийг батлах баримт мэдээлэл хэрэгтэй.

Таны хэрэглэж буй мэдээлэл хүйсийн ялгавартай байдлаар задлан шинжлэгдэж, одоо байгаа мэдээллүүд дотор дутагдалтай байгаа мэдээллийг тодорхойлж байх ёстой. Та мэдээлэл, таамаглалыг бататгаж, шалгахын тулд сонирхогч талуудтай байнга зөвлөлдөх хэрэгтэй

## Алхам 4: Сонголтуудыг боловсруулах

Та хийж буй хэлэлцүүлэг зөвлөгөө, судалгаа нь таны сонголт, зөвлөмжийг санал санаачлагыг боловсруулалт, хэрэгжүүлэлтийн бүх үе шатанд мэдээлэх ёстой.

Таны цуглуулсан мэдээллүүд таны тодорхойлсон тодорхой асуудлуудад хариу өгч байх ёстой.

Хэрэв та өөрийн санаачилга нь ялгаатай үр нөлөөгүй эсвэл санамсаргүй саад бэрхшээлтэй байж болзошгүй гэж үзсэн бол саналаа бэхжүүлэх стратегийг санал болгох. GBA шинжилгээгээр тодорхойлсон мэдээллийн зөрүүг арилгах төлөвлөгөөгөө гаргах.



## Алхам 5: Хяналт, үнэлгээ

Үнэлгээний хүрээ, мониторинг хийх аргын загвар нь тэгш бус байдлыг олж тогтоох, чадавхийг бий болгоход туслах болно

Таны хийж үнэлгээ нь сонирхогч талуудын эерэг болон сөрөг санал бодлыг тусгасан эсэхэд анхаараарай

Мөн энэ алхам нь орхигдож **хаягдсан мэдээллүүдийг** олж илрүүлэхээс гадна таны **таамаглаагүй үр дүнг** мөн тодруулж гаргаж ирнэ

# Алхам 6: Харилцаа холбоо

Жендэрийн хэтийн төлөв нь харилцаа холбооны бодлогод тусгагдах талаар дараах зүйлийг авч үзнэ:

- Ямар нэг мэдээ мэдээлэл нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд аль алинд нь тохирсон байх ёстой;
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүст мэдээлэл хүргэх харилцаа холбооны стратегийг төлөвлөх, тэдэнд хэрхэн мэдээлэл хүргэх, бодлого дах жендэрийн ойлголтыг тодруулах;
- бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх үйл явцад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алины оролцоо, хувь нэмрийг хэрхэн яаж үнэлэх, харилцан хуваалцах.

Эцэст нь хэлэхэд өөрийн байгууллагын GBA-ийн үр дүнг хуваалцах буюу хэлэлцэхийг санаарай. Ингэснээр оролцогч бүлгүүдийн дэмжлэгийг авах, цаашид авах арга хэмжээний талаар нарийвчлан судлах боломжтой болно.

## Алхам 7: Баримт бичиг

Таны санаачилга, судалгааны туршид дүн шинжилгээ, дүгнэлтээ баримтжуулах нь маш чухал юм.

- Мэдээлэл, дүн шинжилгээ нь таны тайлан зөвлөмжийг суурь мэдээллээр хангаж өгдөг.
- Удирдах зөвлөлийг зохион байгуулж, таны зөвлөмжийг хэрэгжүүлсэн үйл явцын талаар тайлбарлахыг шаардаж болно.

## 2.0 ҮДСУ гэж юу вэ?

Үр дүнд суурилсан удирдлага (ҮДСУ)

*“гэдэг нь шийдвэр гаргах, ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах стратеги, нөөц, үйл явц хэмжигдэхүүнийг нэгтгэж буй хөтөлбөр эсвэл төслийн удирдлагын аргачлал юм .”*

*(Канадын Гадаад Хэргийн Газар)*

# ҮДСУ нь доорх зүйлд төвлөрнө

- Бодит үр дүн (зорилт)-г тодорхойлж, хэрэгжүүлэх
- Үр дүнтэй үзүүлэлтүүдийг ашиглан явцын байдлыг хянах, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг тайлагнах хэмжилтийн системийг хэрэгжүүлэх
- Хүссэн үр дүнд хүрэхийн тулд болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох ба удирдах
- Сургамжуудыг нэгтгэх замаар байгууллагын шийдвэр гаргалтын үр дүн, оновчтой байдлыг сайжруулах


## 2.2 Үр дүнгийн гинжин хэлхээ гэж юу бэ?

(“ Логик загвар” гэж ойлгогддог )

Энэ нь ---- дүрсээр эсвэл “логик холбоогоор” учир шалгааныг харуулдаг

Өөрөөр хэлбэл тодорхой бодлого, хөтөлбөр ба санаачилгын хүрээнд *орц, үйл явц, гарц ба үр нөлөөнүүдийн* хоорондын хамаарал

Энгийн шугаман үр дүнгийн гинжин холбоо



# Жендэрийн дүн шинжилгээ ба үр дүнгийн хэлхээ

Үр дүнгийн хэлхээ: Хөдөөгийн эмнэлэгийг жендэрийн мэдрэмжтэй болгох

Төлөвлөлт

Үр дүнгийн хэлхээ	Орц: Санхүү, материал, мэргэжилтэн	Үйл ажиллагаа: Хэрэгжүүлэх төлөвлөгөө ба засварын ажил
Асуудал	Жендэрийн тэгш байдлыг хангасан мэдлэгийг цуглуулсан байх.	Орон нутгийн иргэдийг жендэрийн тэгш байдлыг хангасан мэдээллээр хангах. Ажилтнуудыг сургалтанд хамруулах (2 хүйсийн хүмүүсийг).
Таамаглал	Жендэрийн асуудлыг төсвийг тодорхойлох ажилд хэрэгтэй	Сургалтанд хамрагдсан эмэгтэйчүүд илүү хүлээн авах чадвар сайтай. Орон нутгийн иргэд төрөл бүрийн хэрэгцээнд нээлттэй хандана.
Судалгаа	Эрэгтэй/эмэгтэй хүний болон охид/хөвгүүдийн тусгай хэрэгцээ	Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр. Архитектурын шаардлагуудын мэдлэг сайжруулсан байна.
Сонголтууд	Төслийг хэрэгжүүлэхэд хүрэх үр нөлөө: илүү олон эмнэлгүүд үү эсвэл жендэрийн мэдрэмжтэй эмнэлгүүд үү?	Орон нутгийн асуудлуудын дагуу анхны төлөвлөгөөг өөрчлөх.

# Жендэрийн дүн шинжилгээ ба үр дүнгийн хэлхээ

Үр дүнгийн хэлхээ: Хөдөөгийн эмнэлэгийг жендэрийн мэдрэмжтэй болгох

Богино хугацааны үр дүн

Үр дүнгийн хэлхээ	Гарц: нөхцөл болон асуудлын дагуу эмнэлгүүд жендэрийн мэдрэмжтэй болсон байна.	Шууд үр дүн: үйлчилгээ өссөн байна, хамрах хүрээ өргөжсөн байна.
Асуудал	Ажиллах цаг нь эрэгтэй <u>болон</u> эмэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангадаг. Ажилтнууд эрх тэгш угтаж авдаг.	Бага насны хүүхдүүдтэй эхчүүдийн эмнэлэгээс дундаж зай
Таамаглал	Үйлчүүлэгчийн харилцаа эмнэлэгийн үйл аижллагааны амжилт, уналтыг тодорхойлж магадгүй.	Богино хугацаанд захын олон тосгон үр шимийг арай бага хүртэнэ.
Судалгаа	Урьдчилсан ирцийн статистикийн дүн шинжилгээ: хоног, долоо хоног, сар.	GPS мэдээллийн санг ашиглан хэрэглэгчдийн хаанаас ирсэн талаар судалгаа хийх.
Сонголтууд	Нээлтийн уян хатан цаг; Мэргэшсэн ажилтнуудын ээлж.	Тээврийн сонголтыг тодорхой болгосоноор дунджаас доогуур хандалттай тодорхой эмнэлгүүдийн хүрэлцээ ихсэх.



# Жендэрийн дүн шинжилгээ ба үр дүнгийн хэлхээ

Үр дүнгийн хэлхээ: Хөдөөгийн эмнэлгийг жендэрийн мэдрэмжтэй болгох

Урт хугацааны үр дүн

Үр дүнгийн хэлхээ	Дунд хугацааны үр дүн: Үйлчилгээний тоо өсч, чанар сайжирсан байна.	Эцсийн үр дүн: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд сайжирсан байна.
Асуудал	Жендэрийн үзүүлэлтээр үйлчилгээний тоо, чанарын зөрүү	Энэ төсөлд хамрагдсан орон нутаг төсөлд хамрагдаагүй орон нутгаас илүү үр шимийг хүртсэн үү?
Таамаглал	Эмнэлэгийн үйлчилгээний тал дээл эрэгтэйчүүд илүү хяналттай болсон байна.	Энэхүү төсөл 2 жендэр дээр хэмжигдэхүйц үр нөлөөг гаргасан байна.
Судалгаа	Хүйсийн тэнцвэртэй эмнэлгийн тайлангууд дээр тулгуурласан судалгаа	Хүйсээр ялгасан, удаан хугацаанд судлагдсан мэдээлэл, өгөгдөл
Сонголтууд	Дүн шинжилгээний үр дүнтэй хамт үйлчилгээний хүргэлтийн баримтыг хянан үзэх.	Санамсаргүй хяналттай туршилтын аргачлал ашиглан үр нөлөөллийн үнэлгээг зохион байгуулах.

# Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт

Жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүд нь хөгжлийн хөтөлбөр, төсөлд **жендэрийн зорилтууддаа** ямар хэмжээтэй, хэрхэн хүрж, **жендэрийн тэгш байдлыг** хангахад чиглэсэн үр дүнд хүрч байгааг харуулдаг. Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт нь цаг хугацааны явцад нийгэмд жендэртэй холбоотой өөрчлөлтүүдийг хэмждэг.

Менежерүүд жендэр чухал хүчин зүйл гэдгийг үргэлж санаж төслийн **үе шат бүрт** шалгуур үзүүлэлт тодорхойлох шаардлагатай бөгөөд **төслийн зорилго**, ерөнхий зорилтууд, үе шат бүрийн тодорхой зорилтууд дээр тулгуурлан үргэлжлүүлэн хийх нь чухал.

# Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт: сайн уу, муу юу?

Эмнэлэгийн төсөл: **шууд үр дүн**

1. 6 дугаар сард үйлчлүүлсэн өвчтний тоо
2. Вакцин хийлгэсэн охид, хөвгүүдийн хувь
3. Жирэмснээс хамгаалах мэдээлэл өгөх үйл ажиллагаанд оролцсон оролцогчдын нийт тоо
4. 1-5 дугаар сар хүртэл өвчтнүүдийн туулсан замын дундаж
5. Томуугийн талаарх зөвөлгөөний тоо жендэрээр

“Баярлалаа”